



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/435

Мандалговь

Одда тайж ХХК-тай нэмэлт
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 34 дугаар зүйлийн 34.2, 34.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх “Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар”-ын ажлын гүйцэтгэгч “Одда тайж” ХХК-тай байгуулсан ЭМЯ/201902070-ны дугаартай 292,015,437 (хоёр зуун ерэн долоон сая арван таван мянга дөрвөн зуун гучин долоо) төгрөгийн гэрээний дүнг 42,996,135 (дөчин хоёр сая есөн зуун ерэн зургаан мянга нэг зуун гучин тав) төгрөгөөр нэмэлт гэрээ байгуулсугай.

Хоёр. Нэмэлт батлагдсан зураг төсвийн дагуу “Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар (Өлзийт)”-ыг чанартай хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Одда тайж” ХХК-ны захирал (Д.Ундармаа)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай нэмэлтгэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгийн газрын дарга (Ц.Эрдэнсүрэн), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), Өлзийт сумын Засаг дарга (А.Эрдэнэбат), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ